

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



### Боолчлолын амьдралын төлөөх залбирал

Христ дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй (Ром 8:1). Эмэгтэйчүүдийн боолчлолын нэг хэлбэр бол гэм буруугийн мэдрэмж юм. 2-р Коринт 5:17-д: 'Тий мээс хэн нэгэн Христ дотор байвал тэр шинэ бүтээл мөн. Хуучин өнгөрчээ, шинэ болсон байна.!' Есүс биднийг нүглийн боолчлол, ял шийтгэлийн өвдөлт, буруутгах хүнд дарамт, хуурамч болон жинхэнэ гэм буруугийн дарамтаас чөлөөлдөг. Христ доторх эрх чөлөө нь туйлын бөгөөд бүрэн юм. Тэр биднийг өнгөрсөн амьдралын зүрх шимшрэм дурсамжуудаас аварч, шинэ амь, шинэ эхлэлийг өгдөг. Христ доторх эрх чөлөө бол бүрэн бөгөөд төгс эрх чөлөө юм.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

үүдэлтэй бэлгийн мөлжлөг, мөрийтэй тоглоомын донтолттой тэмцэж буй хүмүүсийг эрх чөлөөтэй болгож чөлөөлөөч. (Иохан 8:36)

5. Бурхан минь, Чили дэх Гаити, Венесуэл болон бусад улсаас ирсэн цагаачид ялангуяа хөдөө аж ахуй, барилгын салбарт хүнд хөдөлмөрийн нөхцөл, мөлжлөгт өртөж байна. Та тэднийг тэнхрүүлээч хэмээн залбирч байна. (Дэд хууль 27:19)

6. Бурхан минь, Хятадад хүйсийн тэнцвэргүй байдалтай холбоотойгоор бэр болгон зарагдах аюулд өртөж буй эмэгтэйчүүдийг Та хамгаалаач. (Дуулал 32:7)

7. Эзэн минь, Колумбид зэвсэгт мөргөлдөөний улмаас хүнлэг бус нөхцөлд ажиллахаар албадсан хүмүүсийг авраач, тэдэнд хамгаалалт, шударга ёсыг өгөөч. (Исаиа 61:8)

8. Бурхан минь, Доминикан улсад биеэ үнэлэлд татагдсан хүмүүсийг чөлөөлж, ажил хийх эрх чөлөө, сэтгэл санаа болон сүнслэг эдгэрэл олгооч. (Дуулал 107:20)

9. Аав аа, Эсватини дахь хүний наймааны хохирогчдыг чөлөөлж, тэдний шархыг эдгээж, нэр төрийг нь сэргээж, шинэ амьдралын найдвараар дүүргээч. (Исаиа 61:1)

10. Эзэн минь, Этиопт охидыг бага насанд нь гэр бүл болохыг шаардах уламжлал төгсгөл болж, эмэгтэйчүүдийн бичиг үсгийн боловсрол дээшлэх болтугай. (Иеремиа 29:11)

11. Бурхан Аав минь, Индонезид мөлжлөгийн шинжтэй зээлийн дарамтад орсон эмэгтэйчүүдийг чөлөөлж, санхүүгийн эрх чөлөө, амар тайвныг олгооч. (Дуулал 72:4)

12. Бурхан минь, Японд бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг аварч, тэдэнд туслах хүмүүст хүч өгөөч. (2 Тесалоник 3:3)

13. Бурхан минь, Мексикийн аялал жуулчлал, хил орчмын бүсэд амьдардаг эмэгтэйчүүд, охидыг хүний наймаанаас хамгаалаач. Чуулган болон төрийн байгууллагыг тэднийг хамгаалахад босгооч. (Исаиа 1:17)

1. Эзэн Бурхан минь, Албани дахь эмэгтэйчүүдийн хорих газруудад буй итгэгчдэд зориг, хүч өгч, тэд гэрчлэлээ эргэн тойрныхондоо чөлөөтэй хуваалцах боломжийг олгооч. (2 Тимот 1:8)

2. Ааваа, Бонэйрт бэлгийн болон хөдөлмөрийн боолчлолд өртөгсдөд тусалж, найдвар өгч чадах чуулгануудыг босгон байгуулж өгөөч. (Дуулал 72:12)

3. Эзэн, Бразилийн хойд нутгийн мөлжигдөж буй хөдөө орон нутгийн ажилчдад шударга ёс тогтоож, эрх баригчдыг хөдөлмөрийн хуулиа сахиулахад туслаач. (Сургаалт үгс 14:31)

4. Эзэн минь, Камбожид интернэт ашиглалтаас

14. Эзэн минь, Монголын төр засаг хүний наймаа, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрийн эсрэг хууль гаргаж, залуусыг хамгаалах болтугай. (1 Тимот 2:1-2)

15. Аав аа хүний эрх хамгаалахын төлөө хоригдож буй Мьянмарын эмэгтэйчүүдэд шударга ёс, хүч өгөөч. Тэдэнтэй хамт байгаа хүүхдүүдийг хамгаалаач. (Сургаалт үгс 21:15)

16. Бурхан минь, Нидерландын Улаан гэрлийн дүүрэгт амьдарч буй биеэ үнэлэгчдийг хамгаалж, Таны гэрлийг харахад туслаач. (2 Коринт 5:17)

17. Бурхан минь, Никарагуад бага насны охидыг хүчээр гэрлүүлэх явдлын эсрэг хууль батлагдаж, ийм заншлыг дэмждэг соёлыг өөрчлөөч. (Дуулал 140:12)

18. Эзэн минь, Украин-Оросын дайнд оролцож буй Хойд Солонгосын хүүхдүүдийн эцэг эхийн зүрхийг тайтгаруулж, энх тайван тогтож, гэр бүлүүдийг эргэн уулзах болтугай. (2 Коринт 13:11)

19. Эзэн, Папуа Шинэ Гвинейд эмэгтэйчүүдийг үл ойшоож, бага насанд нь гэрлэхийг албадаж буй уламжлалуудыг өөрчлөөч. Тэдний үнэ цэнэ, нэр төрийг сэргээж өгөөч. (Исаиа 58:6)

20. Бурхан Аав минь, Парагвайд гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй, эрхийг хамгаалж, тэднийг аюулгүй орон байраар хангаач. (Дуулал 82:3)

21. Эзэн минь, Румынд гэр бүл болон ажлын байрандаа хүчирхийлэлд өртдөг эмэгтэйчүүдийг хамгаалж, тэднийг дарамтлагчдаас чөлөөлж, Таны зам руу хөтөлөхөд туслаач. (Дуулал 64:1)

22. Аав аа, ОХУ-д хүний наймааны хохирогч болсон хүмүүст бүх талаас нь эдгэрэл, сэргэлт, найдвар өгөөч. (Иеремиа 30:17)

23. Бурхан минь, Өмнөд Африкт хүний наймаа, хулгай улам газар авч байна. Хохирогчдыг чөлөөлж, эдгээж, энэ гэмт хэргийн бүлгүүдийг устгаач. (Дуулал 82:4)

24. Эзэн, Испанийн эмэгтэй хоригдлууд Таныг таньж мэдсэнээр гэр бүлээ хайрлаж, тэднийхээ төлөө анхаарал халамж тавих зүрхийг өгөөч. (Исаиа 49:15)

25. Бурхан минь, Швейцарийн хорих газруудад буй хүмүүс Библийг унших хүсэл, цангаагаар дүүрч, авралын урилгад зүрхээ нээх болтугай. (1 Тимот 2:4)

26. Эзэн, Танзани улсад амьдралын бэрхшээлээс үүдэн маш их зээл авч, эд хөрөнгөө алддаг эмэгтэйчүүдэд өөрийгөө тэжээх арга замыг нээж өгөөч. (Сургаалт үгс 22:7)

27. Бурхан Аав минь, Тимор-Лестийн дайны мөлжлөгт өртсөн хүүхдүүдийг эдгээж, амьдралыг нь сэргээж, хамгаалалтаа өгөөч. (Матай 19:14)

28. Аав аа, Венесуэлд хүчирхийлэл, эдийн засгийн хүндрэл, эрх чөлөөний хомсдолоос болж дүрвэсэн хүмүүст хамгаалалт, сэргэлт, шинэ амьдрал өгөөч. (Гашуудал 3:34)

29. Бурхан минь, Вьетнамд эмэгтэйчүүдийн гуравны хоёр нь хамтран амьдрагчийн хүчирхийлэлд өртдөг. Тэднийг хамгаалж, тайтгаруулж, амьдралыг нь өөрчилж өгөөч. (Дуулал 34:18)

30. Эзэн минь, Албани дахь хорих газрын эмэгтэйчүүдтэй хамтран ажиллаж буй Арта, Вита нарыг дамжуулан хайраа түгээж, харуул хамгаалалт, сайн харилцааг бүрдүүлээч. (Иохан 13:34–35)

31. Бурхан минь, Гаитид албадан хөдөлмөр хийж, хүчирхийлэлд өртөж буй хүүхдүүдийг чөлөөлж, сэтгэл санааг нь эдгээж, сайн сайхан амьдрал өгөх болтугай. (Дэд хууль 10:18)

#### **Монголын төлөө залбирах сэдвүүд -----**

1. Нэвтрүүлэг илүү олон сувгаар хүрэх боломж нээгдэхийн төлөө
2. залбиралын хуанли хүлээн авдаг чуулган болон хүмүүс нэмэгдэж, залбиралын цугларалт өргөжихийн төлөө
3. Эмэгтэйчүүдийн хориход нэвтрүүлэг цацагдахын төлөө

#### **후원안내**

**국민은행 851-01-0003-724 북방선교방송**

**최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.**